



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/108

Сүхбаатар сум

### Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 24, 26, 27, 43, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалтыг зөрчсөн хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосноос хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд захирамжаар олгогдсон талбайд үйл ажиллагаа явуулаагүй, тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөөгүй зэрэг бодит нөхцөл байдал тогтоогдсон тул Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/399 дугаартай захирамжийн 3 дугаар хавсралтаар олгогдсон "Сэвсгэр тариалан" нөхөрлөлийн тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцсугай.

2. Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/399 дугаартай захирамжийн 3 дахь заалтыг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрөл олгогдсон талбайд байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалт хийх шаардлагатай эсэх, тухайн газрын чанар байдлын талаар дүгнэлт гаргаж 2020 оны 05 дугаар сарын 05-ны дотор ирүүлэхийг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Стгонхүү/-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /А.Эрдэнэгэрэл/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш ОРГИЛ